

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖАРГАЛАНТ СУМЫН 14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/85/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2021 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Х

khovd@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 70432545 Цахим хаяг:

Тунгалаг бүртгэл Аудит ХХК

Аудитор: Ч.Мөнхцооз

Утас: 99028555

Цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## **Агуулга**

---

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	4
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	4
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН.....	4
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....	5
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	7
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....	7
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН.....	8
3.Аудитын тайлан.....	8
3.1. Ерөнхий зүйл.....	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	9
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	12
Аудитын зөвлөмж.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд: .....	13
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	14

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ЖАРГАЛАНТ СУМЫН 14 ДҮГЭЭР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
О.ТУНГАЛАГ ТАНАА

2021.02.18 № 275  
ТӨШИЙ \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

00100027

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,756,675.20</b>	<b>57,366,415.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,054,995.20	69,047.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,040,434.20	68,771.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	14,561.00	276.00
3351	Байгууллагаас авах авлага	14,561.00	276.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	34,701,680.00	57,297,368.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	1,415,500.00
35130	Эм боох материал	-	1,415,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	34,701,680.00	55,881,868.00
35460	Хүнсний материал	303,080.00	5,372,400.00
35470	Бусад хангамжийн материал	34,398,600.00	50,509,468.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>549,017,510.61</b>	<b>548,218,334.21</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	549,017,510.61	548,218,334.21
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	549,017,510.61	547,875,584.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	530,927,001.25	530,927,001.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,577,923.98)	(38,216,264.58)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,147,905.00	34,146,905.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,734,141.21)	(21,326,828.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,225,265.00	65,277,891.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,970,595.45)	(22,933,119.93)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	342,750.04
39301	Програм хангамж		457,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(114,249.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>584,774,185.81</b>	<b>605,584,749.21</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,005,704.00</b>	<b>52,500.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,005,704.00	52,500.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,005,704.00	52,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	52,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>583,768,481.81</b>	<b>605,532,249.21</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	583,768,481.81	605,532,249.21
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	192,933,449.56	214,697,216.96
51210	Өмнөх үеийн үр дүн	192,933,449.56	193,390,449.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	21,306,767.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	390,835,032.25	390,835,032.25
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>584,774,185.81</b>	<b>605,584,749.21</b>

### 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>380,811,855.00</b>	<b>445,381,494.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,354,458.00</b>	<b>48,389,494.26</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,354,458.00	48,389,494.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,354,458.00	48,319,494.26
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,354,458.00	48,319,494.26
120009	Бусад орлого	-	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>372,457,397.00</b>	<b>396,992,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	321,334,200.00	347,398,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,399,800.00	347,398,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	45,284,100.00	49,593,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,284,100.00	49,593,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>378,472,441.10</b>	<b>424,074,726.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>378,472,441.10</b>	<b>424,074,726.86</b>

**Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	372,633,344.10	406,309,914.36
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	215,766,932.00	262,643,309.03
210101	Үндсэн цалин	203,366,838.00	256,375,655.03
210102	Нэмэгдэл	12,400,094.00	6,267,654.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,391,926.46	36,552,534.67
210201	Тэтгэврийн даатгал	19,541,123.39	24,965,129.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,361,788.61	3,224,953.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,746,070.88	2,352,136.44
210204	Ажилгүйдлийн даатгал	446,885.62	587,709.08
210205	Эрүүл мэндийн даатгал	4,296,057.96	5,422,606.04
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,917,889.00	42,676,688.00
210301	Гэрэл, цахилгаан	3,072,608.00	1,677,381.00
210302	Түлш, халаалт	29,856,030.00	28,495,459.00
210303	Цэвэр, бохир ус	7,989,251.00	12,503,848.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,641,700.00	1,911,000.00
210401	Бичиг хэрэг	744,800.00	734,500.00
210402	Тээвэр, шатахуун	70,000.00	60,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,600.00	75,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	680,100.00	1,041,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	52,873,770.00	23,428,580.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	131,700.00	735,000.00
210502	Хоол, хүнс	52,600,570.00	22,693,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,995,600.00	237,000.00
210604	Урсгал засвар	3,995,600.00	237,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	109,200.00	75,000.00
210702	Дотоод албан томилолт	109,200.00	75,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	146,800.00	1,478,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,046,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	146,800.00	432,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	28,789,526.64	37,307,802.66
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,611,926.64	37,307,802.66
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,839,097.00	17,764,812.50
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	17,764,812.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,764,812.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>2,339,413.90</b>	<b>21,306,767.40</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,339,413.90</b>	<b>21,306,767.40</b>

**2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>372,457,397.00</b>	<b>397,062,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>70,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	70,000.00
120009	Бусад орлого	-	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>372,457,397.00</b>	<b>396,992,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	321,334,200.00	347,398,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	24,934,400.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,399,800.00	347,398,100.00

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	45,284,100.00	49,593,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,284,100.00	49,593,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,839,097.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,839,097.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>357,018,297.00</b>	<b>397,062,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>357,018,297.00</b>	<b>397,062,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>351,179,200.00</b>	<b>379,297,187.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	214,961,196.00	262,420,308.03
210101	Үндсэн цалин	166,316,257.00	153,314,993.29
210102	Нэмэгдэл	34,703,639.00	76,453,593.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,017,000.00
210104	Урамшуулал	13,941,300.00	16,634,720.76
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,138,233.00	35,738,291.47
210201	Тэтгэврийн даатгал	20,886,833.00	25,098,191.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,020,000.00	2,660,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,693,100.00	2,128,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	412,500.00	532,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,125,800.00	5,320,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,822,350.00	42,676,688.00
210301	Гэрэл, цахилгаан	3,012,608.00	1,677,381.00
210302	Түлш, халаалт	29,820,491.00	28,495,459.00
210303	Цэвэр, бохир ус	7,989,251.00	12,503,848.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,959,200.00	2,761,000.00
210401	Бичиг хэрэг	744,800.00	734,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	130,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	110,100.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	899,300.00	1,891,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	50,347,350.00	29,533,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	107,500.00	1,770,500.00
210502	Хоол, хүнс	49,807,850.00	27,762,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	432,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,552,200.00	4,227,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,990,000.00
210604	Урсгал засвар	3,552,200.00	237,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	75,000.00
210702	Дотоод албан томилолт	-	75,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,197,100.00	1,478,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,765,100.00	1,046,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,201,571.00	387,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	581,471.00	387,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	620,100.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,839,097.00</b>	<b>17,764,812.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,839,097.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,839,097.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	17,764,812.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,764,812.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>15,439,100.00</b>	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	15,439,100.00	-

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		390,835,032.25	215,985,435.66		606,820,467.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	390,835,032.25	215,985,435.66	-	606,820,467.91
C07	Тайлант үеийн үр дүн			(23,051,986.10)		(23,051,986.10)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	390,835,032.25	192,933,449.56	-	583,768,481.81
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	390,835,032.25	192,933,449.56	-	583,768,481.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			457,000.00		457,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	390,835,032.25	193,390,449.56	-	584,225,481.81
D08	Тайлант үеийн үр дүн			21,306,767.40		21,306,767.40
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	390,835,032.25	214,697,216.96	-	605,532,249.21

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	396,992,000	379,227,188
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	396,992,000	379,227,188
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	396,992,000	379,227,188
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	266,001,500	262,420,308
210101	Үндсэн цалин	177,886,700	153,314,993
210102	Нэмэгдэл	65,772,600	76,453,594
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,402,700	16,017,000
210104	Урамшуулал	19,939,500	16,634,721
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,910,300	35,738,291
210201	Тэтгэврийн даатгал	25,270,200	25,098,191
210202	Тэтгэмжийн даатгал	2,660,000	2,660,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,128,000	2,128,000
210204	Ажилгүйдлийн даатгал	532,000	532,000
210205	Эрүүл мэндийн даатгал	5,320,100	5,320,100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	48,471,000	42,676,688
210301	Гэрэл, цахилгаан	3,665,800	1,677,381
210302	Түлш, халаалт	32,261,700	28,495,459
210303	Цэвэр, бохир ус	12,543,500	12,503,848
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	505,900	2,774,500
210401	Бичиг хэрэг	105,400	734,500
210402	Тээвэр, шатахуун	61,700	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,600	75,000

210404	Ном, хэвлэл	60,200	6,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		60,000
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,899,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>43,075,700</b>	<b>30,049,900</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,926,500	1,770,500
210502	Хоол, хүнс	40,234,600	27,762,900
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	914,600	516,500
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,122,900</b>	<b>3,627,000</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,390,000
210604	Урсгал засвар	1,122,900	237,000
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>109,200</b>	<b>75,000</b>
210702	Дотоод албан томилолт	109,200	75,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>575,600</b>	<b>1,478,000</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600	1,046,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000	432,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,219,900</b>	<b>387,500</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	387,500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,219,900	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>396,992,000</b>	<b>379,227,188</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>347,398,100</b>	<b>329,633,288</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	347,398,100	329,633,288
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>49,593,900</b>	<b>49,593,900</b>
132001	Орон нутгийн төсвөөс	49,593,900	49,593,900

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэмэлт санхүүжилт байхгүй байна.

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч О.Тунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зардлыг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах үнэн бодитойгоор тайлагнах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 1-ны хооронд Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны ахлах аудитор Ч. Мөнхцооз хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Багш бүр хичээл сургалтыг чанартай зааж, эцэг эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тоглоомоор дамжуулан хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэхийг үндсэн зорилгоо болгон ажиллажээ.

2020 оны хичээл сургалтын үйл ажиллагаанд заах аргын нэгдэл, баг хамт олны бэлтгэлийг чанар үр дүнтэйгээр зохион байгуулж өдөр тутмын хичээл сургалт, хүүхэд хөгжүүлэлтийг чанарын өндөр түвшинд зохион байгуулж зорилтын дор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Хичээл сургалтын үйл ажиллагаанд багшийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн "Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд ажлын байрандаа хөгжих, чадваржих боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигтэй болох, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэн, "Авьяас", "Номын гэгээ", "Хүүхэд бүр цэцэрлэг" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар хүүхдийн хөгжлийг дэмжих
- Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжин ажиллах, улмаар олон нийтийн оролцоот шилдэг цэцэрлэг болсон туршлагыг аймаг, улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх сурталчлах
- Ахмадын зөвлөх үйлчилгээ, англи хэл, олон ястан үндэстний уламжлалт тоглоом наадгай зэрэг чиглэлүүдэд тусгайлсан хөтөлбөр боловсруулан ажиллана гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот "бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот "Хоолны зардлын норматив тогтоох тухай"

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн удирдлага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна. Мөн тус газраас Шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил арилгах х арга хэмжээ авагдаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2% хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 423617,7 мянган төгрөгөөс нэг хувиар тооцон 4236,2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20353.5 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын болон үндсэн хөрөнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,054,995	69,047	985,948
Бараа материал	34,701,680	57,297,368	-22,595,688
Үндсэн хөрөнгө	549,017,511	548,218,334	799,176
<b>Нийт хөрөнгө</b>	<b>584,774,186</b>	<b>605,584,749</b>	<b>-20,810,563</b>
Өр төлбөр	1005704	52500	953,204
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	583,768,482	605,532,249	-21,763,767
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>584,774,186</b>	<b>605,584,749</b>	<b>-20,810,563</b>

Мөнгөн хөрөнгө үлдэгдэлгүй, авлага дансны үлдэгдэл 985,9 мянган төгрөгөөр буурсан нь НДШ болон ХХОАТ-н тооцоо буруу хийснээс илүү шилжүүлсэн дүнг буцаан суутган тооцсонтой холбоотой байна.

Бараа материал данс 22595.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь цар тахалтай холбоотой ариутгах бодис маск, хамгаалах хувцас зэргийн үлдэгдэл 1415,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн болон утаанаас хамгаалах зориулалтаар 3390,0 мянган төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг цонхонд агаар шүүгч суулгасан, 850,0 мянган төгрөгийн вакум хаалтыг гадна үүдэнд хийж бүртгэлд тусгасан. Гурил, будаа сахар мах /431 кг мах 144 кг гурил сахар 63 кг/ нөөцөлсөнтэй холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дунд голын рашаан ХХК-ны бэлтгэн нийлүүлсэн 40950,5 мянган төгрөгийн суурин болон жижиг ширхгийн тоглоом наадгай, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар ширээ сандал вандан тавиур зэрэг 912,6 мянган төгрөгийн эд хогшил, Жаргалант сумын ОНХСангаас санхүүжүүлэн бэлтгэж нийлүүлсэн өнгөт принтер, зөөврийн компьютер, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 2 ширхэг 3499,0 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер зэрэг эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө хүлээн авч бүртгэн тайлан тэнцэлд тусгажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1256,1 мянган төгрөгөөр буурсанд тайлант жилийн элэгдлийн 37307,8 мянган төгрөг ихээхэн нөлөө үзүүлж байгаа боловч дээрх хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн үндсэн хөрөнгийн орлогын өөрчлөлтөөс хамаарсан байна.

#### Хүснэгт 2 Орлогын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Улсын төсвөөс олгосон санхүүжилт	321,334,200	347,398,100	26,063,900
Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт	45,284,100	49,593,900	4,309,800
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	8,354,458	47,862,494	39,508,036
бусад орлого, санхүүжилт	5,839,097	70,000	(5,769,097)
<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>380,811,855</b>	<b>444,924,494</b>	<b>64,112,639</b>

Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн нийт орлого өмнөх оноос 64112,6 мянган төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн байна. Улсын төсвийн санхүүжилт 1 эмчийн орон тоо нэмэгдсэнтэй холбоотой цалингийн зардал өссөн болон Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй, харин орон нутгийн төсвийн санхүүжилт цэвэр бохир усны төлбөр нэмэгдсэнтэй холбоотой, үнэ төлбөргүй орлого тайлант оны хөрөнгө оруулалтаас тус тус хамааралтай өсжээ.

#### Хүснэгт 3 зардлын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ	244,158,858	299,162,058	55,003,200
Байр ашиглалттай холбоотой зардал	40,917,889	43,388,473	2,470,584
Хангамж бараа материалын зардал	1,641,700	810,200	(831,500)
нормативт зардал	52,873,770	23,971,880	(28,901,890)
Бусад бараа үйлчилгээний зардал	33,041,127	38,520,304	5,479,177
бусад урсгал шилжүүлэг	5,839,097	17,764,812	11,925,715
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>378,472,441</b>	<b>423,617,727</b>	<b>45,145,286</b>

Нийт зардал өмнөх оноос 45145,2 мянган төгрөгөөр буюу 11,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, шимтгэлийн зардал 55003,2, бусад урсгал зардал 9857,9 мянган төгрөгөөр буурсан материаллаг өөрчлөлт гарчээ. Энэ нь халаалтын хугацаа 1 сараар хойшилсон, цаг үеийн нөхцөл байдлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай хамааралтай байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 440188,1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 440188,1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43196,1 мянган төгрөгөөр бууруулж 396992,0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 396992,0 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 347398,1 орон нутгийн төсвөөс 49593,9 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 347398,1 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 49593,9 мянган төгрөг, нийт 396992,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 379227,2 мянган төгрөгийг зарцуулж 17764,8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлангийн хугацаанд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд хэрэгжүүлсэн горим сорилын дүнгээр алдаа зөрчил илэрсэнгүй.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зардлыг зардлын зүйл анги хооронд гүйлгэн зарцуулсан, хөрөнгө дутуу бүртгэсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн уг зөвлөмжийн хэрэгжилт 90 орчим хувьтай байна. Тайлангийн хугацаанд зарим зардлууд бодитойгоор тайланд тусгагдаагүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 36227,9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21534,8 мянган төгрөгийн алдааг залруулж, 3 хүнтэй холбоотой 691,35 мянган төгрөгийг төлүүлэх акт тогтоож, 4 чиглэлийн 14001,8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн түлш халаалтын зардалд 3390,0 мянган төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг агаар шүүгчийн үнийг бүртгэн тайлагнасан
- 380,0 мянган төгрөгийн үнэ бүхий маскны үнийг бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлсэд бүртгэн тайлагнасан
- Дээд шатны төсөв буцаан төвлөрүүлсэн 17764,8 мянган төгрөгийг тухайн зардал бүрээр зардлаар тайлагнасан зэрэг залруулгыг хийлээ.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар илэрсэн 691,3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоою.

Үүнд:

Ажиллагсадад 57895 төгрөгийг илүү, 126875 төгрөгийг дутуу тооцож олгосон, цэцэрлэгийн эмчийн цалинд 506581 төгрөгийг бэлнээр олгосон гэх боловч санхүүгийн ямар

нэгэн баримт байхгүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг авлага, төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, заалттай нийцэхгүй, үнэн зөв бодистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: нийт 691351 төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн зөрчилд дараах зөвлөмжүүдийг өгч, менежментийн захидалд тусгав. Үүнд:

- Эд хариуцагчийн тооцоог бодож актаар баталгаажуулаагүй
- НӨАТ-н баримт зарим ажил гүйлгээнд аваагүй
- Тайлангийн үеийн нөхцөл байдлын улмаас ажиллагсадын нийгмийн асуудал амьжиргааг дэмжих үүднээс унаа хоолны хөнгөлөлтийг батлагдсан дүнгээс 13614.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон алдаа зөрчлийг засаж залруулах,
- Зардлыг үнэн зөв тооцон бүртгэж бодистойгоор тайлагнах
- Өмнөх онуудад Санхүүгийн хяналт шалгалтаар тавигдсан 387,5 мянган төгрөгийн актыг төсвөөс төлсөн
- 

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД:**

- Хүүхдийн хоолны хэмнэгдсэн зардлаас 380.0 мянган төгрөгийн маскийг Буянт үйлийн шим ХХК-нд нийлүүлсэн зэрэг асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгдсэн тайланд аймгийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **Зардлын данстай холбоотой асуудал.**

1.1. **Илрүүлэлт:** Жилийн эцсийн тооллогыг эрхлэгчийн тушаалаар баталсан комисс тооллого хийсэн нэх боловч тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна.

**Эрсдэл:** Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн хууль, тэдгээрийг хэрэгжүүлэх журам дүрэм зөрчигдөх

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д заасан иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д заасан анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

2.1. **Илрүүлэлт:** Зарим зардлыг зүйл ангийг зөв тодорхойлж бүртгээгүйгээс тухайн зардлыг бодистойгоор тайлагнаж байх

**Эрсдэл:** төсвийн гүйцэтгэлийг буруу тайлагнах

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 5.1.2-д төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг нагнасан байх гэснийг анхаарч ажиллахыг зөвлөв.

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвшөөрч байна.

3.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу

**Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар** Зөвшөөрч байна.

4.1. **Илрүүлэлт:** Батлагдсан төсөвт унаа хоолны хөнгөлөлт 2402.7 мянган төгрөг батлагдсан гүйцэтгэлээр 16017.0 мянган төгрөг олгож 13132.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон

**Эрсдэл:** Төсвийг бодитойгоор төлөвлөж зөв зохистойгоор хувиарлах

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** анхаарч ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2020			ХОАГ-

Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэг</b>	Мянган төгрөгөөр
------------------------------	---	------------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	агаар шүүгчийн үнийг халаалтын зардалд бүртгэн тайлагнасан	3390,0	Залруулга	Эрхлэгч Ня-бо	О.Тунгалаг М.Одгэрэл
2	Маскийн үнэнд мөнгө шилжүүлсэн боловч уг маск ирээгүй байхад бараа материал дансанд хөндий орлого авч зарлага гаргасан	380.0	Залруулга	Эрхлэгч Ня-бо	О.Тунгалаг М.Одгэрэл
3	Мөнгөн гүйлгээний тайланд буцаан төвлөрүүлсэн дүнг тухайн хэмнэгдсэн зардалд бүртгэсэн	17764,8	Залруулга	Эрхлэгч Ня-бо	О.Тунгалаг М.Одгэрэл
4	Хоол унааны хөнгөлөлтийг батлагдсан төсөв хэртүүлж олгосон	13614,0	Зөвлөмж	Эрхлэгч Ня-бо	О. Тунгалаг М.Одгэрэл
5	Ажиллагсад илүү, дутуу тооцож цалин олгосон	184,7	Акт	Эрхлэгч Ня-бо	О.Тунгалаг М.Одгэрэл

6	Эд харицагчийн тооцоо бодож актаар баталгаажуулаагүй	0	Зөвлөмж	Эрхлэгч Ня-бо	О.Тунгалаг М.Одгэрэл
7	2018 оны эзэн холбогдогч тодорхойгүй акт төсвөөс төлсөн	387.5	зөвлөмж	Эрхлэгч Ня-бо	О. Тунгалаг М.Одгэрэл
8	цэцэрлэгийн эмчийн цалинд 506581 төгрөгийг бэлнээр олгосон гэх боловч санхүүгийн ямар нэгэн баримт байхгүй	506,8	акт	Эрхлэгч Ня-бо	О. Тунгалаг М.Одгэрэл
	ДҮН	35746,1			

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**